МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 27 өдөр Дугаар А/611 Мөрөн сум

Газар эзэмших эрх дуусгавар болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, дэх хэсгийн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/52 дугаар захирамжийн хавсралтын 27 дахь заалтаар газар эзэмшигч хуулийн этгээд "Мөрөн сумын Засаг даргын тамгын газар" (9070192)-ны Мөрөн сум 10 дугаар баг 6712014505 нэгж талбарын дугаартай төрийн захиргааны байгууллагын зориулалтаар эзэмшүүлсэн 11164м2 газрын газар эзэмшигч "Мөрөн сумын Засаг даргын тамгын газар" нь газар эзэмших гэрээгээ цуцлах тухай хүсэлт гаргасны дагуу газар эзэмших эрхийг нь дуусгавар болгож нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байсан газар эзэмшигч хуулийн этгээд "Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар" (9070192)-ын 000003333 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээ, аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/52 дугаар захирамжийн хавсралтын 27 дахь заалтыг тус тус хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011416